



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ


Төлбөрийн тэнцэл

2013 онд урсгал ба хөрөнгийн данс 4,591 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 2,808 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 1,867 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурсан байна. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -84 сая ам.доллар байна.

2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 647 сая ам.доллараар өссөн, харин санхүүгийн дансны ашиг 3,881 сая ам.доллараар буурсан байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант жилийн эцсийн байдлаар 2,248 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.1 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 4,340 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 28,981 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц 2013 оны эцэст 24,642 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино позицтой байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулах бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 28% буюу 5,404 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнд шууд хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 2,443 сая ам.доллар, 1287 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц




Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2013 оны эцэст 19,830 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 15%-иар буюу 2,619 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын гадаад өр 2%-иар буюу 65 сая ам.доллараар буурч 3,535 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 98%-иар буюу 559 сая ам.доллараар өсч 1,131 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 17%-иар буюу 200 сая ам.доллараар өсч 1,376 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 13%-иар буюу 363 сая ам.доллараар өсч 3,199 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 17%-иар буюу 1,563 сая ам.доллараар өсч 10,590 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ДАНС

2013 онд урсгал ба хөрөнгийн дансны тэнцлийн алдагдал 4,591 сая ам.долларт хүрч, алдагдлын хэмжээ 2012 оны мөн үеэс 12%-иар буюу 647 сая ам.доллараар буурчээ.

Үүнд барааны дансны алдагдал 442 сая ам.доллараар, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 116 сая ам.доллараар, анхдагч орлогын дансны алдагдал 204 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлсөн.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 4% -иар буурч 10,187 сая ам.долларт хүрсэн. Тайлант хугацаанд барааны худалдааны тэнцэл өнгөрсөн оноос 422 сая ам.доллараар буурч, 2,608 сая ам.долларын алдагдалтай гарсан.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад тайлант жилд бүх төрлийн автомашины импорт 20%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмжийн импорт 19%-иар буурсан, экспортын бүтээгдэхүүнүүдэд төдийлөн өөрчлөлт гараагүй нь голлон нөлөөлсөн.

Үйлчилгээний худалдаа

2013 онд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 116 сая ам.доллараар буурч 1,310 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдал буурахад бусад үйлчилгээний зардал 127 сая ам.доллараар, үүнд барилгын болон бизнесийн болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардлын бууралт голлон нөлөөлжээ.

Анхдагч орлого

2013 оны гүйцэтгэлээр анхдагч орлогын данс 963 сая ам.долларын алдагдалтай гарч 2012 онтой харьцуулахад алдагдлын хэмжээ 17%-иар буюу 204 сая ам.доллараар буурсан. Үүнд:

- Засгийн газар, банкууд болон ААН-үүд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт нийт 149 сая ам.доллар,
- ААН-үүд гадаадын хөрөнгө оруулагчдын ногдол ашигт 280 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн хүүгийн төлбөрт 432 сая ам.доллар, бусад гадаад зээлийн эх үүсвэрийн хүүгийн төлбөрт 147 сая ам.доллар,
- Банкууд гадаад зээл, харьяат бусын эзэмшлийн харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт 50 сая ам.долларын хүүгийн төлбөр тус тус тооцсон байна.


Хоёрдогч орлого

Энэ дансанд хувийн гуйвуулга болон хандив тусламжийн орлогыг бүртгэдэг бөгөөд 2013 онд гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оноос 26.5%-иар, гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 23.2%-иар тус тус буурсан байна. Ингэснээр ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 16.6 сая ам.доллар болж өмнөх оноос 50.7%-иар буурсан байна.


Хүснэгт 1. Урсгал ба хөрөнгийн тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	2012	2013	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
I. Урсгал тэнцэл	-5,381	-4,732	649	12%
1.1. Бараа	-3,030	-2,608	422	-14%
1.2. Үйлчилгээ	-1,426	-1,310	116	8%
1.3. Анхдагч орлого	-1,167	-963	204	-17%
1.4. Хоёрдогч орлого	242	149	-93	-38%
II. Хөрөнгийн тэнцэл	142	141	-2	-1%
2.1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгө	0	0	0	0%
2.2. Хөрөнгийн шилжүүлэг	142	141	-2	-1%
Урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл	-5,238	-4,591	647	-12%

Дүрслэл 5. Барааны худалдаа



Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Хувийн гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	46,862	22%	▲ 8%	18,225	9%	▼ -9%
Америк	26,033	12%	▼ -14%	34,856	18%	▼ -4%
Хятад	16,543	8%	▼ -69%	37,458	19%	▼ -46%
Гонг Конг	11,607	5%	▼ -55%	9,099	5%	▼ -35%
Англи	13,674	6%	▲ 16%	7,598	4%	▲ 1%
ОХУ	10,985	5%	▲ 5%	8,749	4%	▼ -15%
Сингапур	6,406	3%	▼ -26%	9,056	5%	▼ -44%
Швейцарь	6,964	3%	▼ -61%	1,320	1%	▼ -62%
Герман	11,817	6%	▲ 43%	4,226	2%	▼ -50%
Япон	6,844	3%	▼ -44%	6,300	3%	▲ 6%
Бусад	53,583	25%	▼ -17%	57,790	30%	▼ -7%
НИЙТ	211,319	100%		194,676	100%	

Хүснэгт 3. Хувийн гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)

	2011	2012	2013	Өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	53.0	33.8	16.6	-17.1	-50.7%
Гаднаас орж ирсэн	219.7	287.4	211.3	-76.0	-26.5%
Гадагш шилжүүлсэн	166.7	253.6	194.7	-58.93	-23.2%

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

САНХҮҮГИЙН ДАНС

Санхүүгийн дансны тэнцэл 2013 онд 2,808 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 58%-иар буюу 3,881 сая ам.доллараар буурсан үзүүлэлтэй байна.

Энэхүү бууралт нь шууд болон багцын хөрөнгө оруулалтын дансны эх үүсвэрийн бууралтаас голлон шалтгаалж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2,019 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 2,189 сая ам.доллараар буурсан байна. Энэ нь манай улсын томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа татсан зээлийн эх үүсвэр цэвэр дүнгээр 1,594 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.

Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл,

- Гонг-Конгоос орж ирсэн хөрөнгө оруулалт 2012 онд 1,986 сая ам.доллар байсан бол 2013 онд 1,441 сая ам.долларт,
- БНХАУ-ын хөрөнгө оруулалт 400 сая ам.доллараас 2013 онд 268 сая ам.долларт,
- АНУ-ын хөрөнгө оруулалт 290 сая ам.доллараас 156 сая ам.долларт хүрч буурчээ.

Багцын хөрөнгө оруулалт

2012 онд 2,300 сая ам.долларын ашигтай гарч байсан багцын хөрөнгө оруулалтын данс тайлант онд 161 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Энэ нь тайлант жилд банкны салбарын бондын эргэн төлөлтөд 150 сая ам.долларыг зарцуулснаар тайлбарлагдаж байна.


Бусад хөрөнгө оруулалт

2013 онд бусад хөрөнгө оруулалтын данс 950 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал тэнцэл 769 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Энэ нь манай улсын эдийн засгийн харьяат банк, аж ахуйн нэгж, иргэдийн гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон харьяат бусын байршуулсан харилцах, хадгаламжийн дансны эх үүсвэрийн өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна.

Хүснэгт 4. Санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)				
Үзүүлэлт	2012	2013	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
III. Санхүүгийн тэнцэл	-6,689	-2,808	3,881	58%
3.1. Шууд хөрөнгө оруулалт	-4,208	-2,019	2,189	52%
Гадагш хийсэн	65	41	-24	-37%
Монгол Улсад орсон	4,272	2,060	-2,213	52%
3.2. Багцын хөрөнгө оруулалт	-2,300	161	2,461	107%
3.3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	0	0	0%
3.4. Бусад хөрөнгө оруулалт	-181	-950	-769	424%
Үүнээс: Худалдааны зээл	16	-69	-85	519%
Бэлэн мөнгө харилцах	342	-54	-396	-116%

Хүснэгт 5. ГШХО, улсаар (сая ам.доллар)				
№	Үзүүлэлт	2013		2013/2012
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт
1	Австрали	75.3	3%	-14.6
2	Америк	155.5	7%	-133.9
3	Англи	22.9	1%	-186.9
4	Бельги	1.4	0%	-3.3
5	БНХАУ	268.0	12%	-132.3
6	Герман	9.1	0%	1.6
7	Голланд	9.1	0%	-41.1
8	Гонг-Конг	1441.3	64%	-546.1
9	Канад	26.2	1%	-119.7
10	Люксембург	7.5	0%	-4.8
11	Малайз	4.7	0%	-4.0
12	ОХУ	11.7	1%	-19.0
13	Сингапур	45.0	2%	-80.6
14	Солонгос (өмнөд)	61.0	3%	2.3
15	Швейцарь	6.3	0%	-12.3
16	Япон	45.7	2%	-12.5
17	Бусад	70.4	3%	-13.4
Нийт		2261.0	100%	-1320.7



Алдаа ба орхигдуулга

2013 оны жилийн эцэст алдаа ба орхигдуулга үзүүлэлт -84 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд дотогш чиглэсэн хөрөнгийн урсгал илүү бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2013 оны эцэст -24,641.6 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 24.6 тэрбум ам.доллараар их байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 4,339.8 сая ам.доллар байна. Үүний 50%-ийг гадаад валютын албан нөөц, 32%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг багцын хөрөнгө оруулалт, 8%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 1%-ийг санхүүгийн үүсмэл хэрэгслүүд тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 28,981.4 сая ам.доллар хүрчээ. Үүний 68%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 24%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 9%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 46%-ийг буюу 8,989.2 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 54% буюу 10,590.1 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оноос 28%-иар буюу 5,403.5 сая ам.доллараар өссөн байна.

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 36%-иар буюу 2,413.3 сая ам.доллараар буурсан, гадаад пассив 12%-иар буюу 2,990.2 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,443.3 сая ам.доллараар, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн богино позиц 103.8 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 1,286.8 сая ам.доллараар тус тус өссөнөөр, харин багцын хөрөнгө оруулалтын богино позиц 286.7 сая ам.доллараар тус тус буурсанаар тайлбарлагдаж байна.

Гадаад активын дүн буурсан нь шууд хөрөнгө оруулалтын бууралтаас шалтгаалсан. Харин гадаад пассивын өсөлт нь шууд хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалтын өсөлтийн тодруулбал ААН-үүдйн бусад эх үүсвэрээс авсан зээл болон Засгийн газрын урт хугацаат гадаад зээлийн эх үүсвэрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Компаниудын хувьцааны үнэ


Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ 2013 оны 4-р улиралд өмнөх улирлын хаалтын ханштай харьцуулахад 9%-иар буурчээ.

Хүснэгт 8-с харахад 6 ААН-ийн хувьцааны үнэ буурсан байна. Үүнээс Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Харанга ресурс (Haranga resources) компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 33% байгаа бол Сентерра Гоулд компанийн хувьцаа хамгийн бага буюу 10%-ийн бууралттай байна.


Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-19238	-24642	5404	28%
I. Гадаад актив	6753	4340	-2413	-36%
1. Шууд хөрөнгө оруулалт	883	351	-532	-60%
2. Багцын хөрөнгө оруулалт	485	370	-114	-24%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	49	49	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	1259	1404	145	12%
5. Нөөц актив	4126	2166	-1960	-48%
II. Гадаад пассив	25991	28981	2990	12%
1. Шууд хөрөнгө оруулалт	17668	19579	1911	11%
2. Багцын хөрөнгө оруулалт	2895	2494	-401	-14%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	49	49	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	5427	6859	1432	26%

Дүрслэл 7. Гадаад актив



Дүрслэл 8. Гадаад пассив



Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ

№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					9/30/2013	12/31/2013	
1	Turquoise Hill Resources	IVN	US	USD	4.42	3.30	-25.3%
2	Mongolian Mining Corp	Sep-02	HK	HKD	1.03	1.39	35.0%
3	Centerra Gold	CG	CAD	CAD	4.82	4.32	-10.4%
4	Southgobi Resources	Feb-05	HK	HKD	9.03	6.88	-23.8%
5	Winsway Cocking Coal	Sep-04	HK	HKD	0.62	0.49	-21.0%
6	Mongolia Energy Corp	Oct-00	HK	HKD	0.238	0.24	2.1%
7	Petro Matad	MATD	LN	GBP	3.62	3.88	7.2%
8	Prophecy Coal Corp	PCY	CAD	CAD	0.075	0.08	6.7%
9	Haranga resources	HAR	AU	AUD	0.09	0.06	-33.3%
10	Mongolian Investment Group	Feb-01	HK	HKD	0.40	0.29	-27.5%

IV. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2013 оны эцсийн байдлаар 19,830 сая ам.долларт хүрч өмнөх оны эцсийн гүйцэтгэлээс 2,619 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 65 сая ам.доллараар буурч 3,535 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 599 сая ам.доллараар нэмэгдэж 1,130 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд 2013 онд нийтдээ 2,125 сая ам.доллараар өсч 15,165 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2013 оны эцэст 1,376 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 17%-иар буюу 200 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 40%-ийг урт хугацаат зээл, 29%-ийг бонд өрийн бичиг, 19%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 12%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат зээлийн үлдэгдэл харгалзан 1,116 сая ам.доллар, 260 сая ам.долларт тус тус хүрчээ.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2013 оны эцэст 13,789 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,925 сая ам.доллараар өссөн.

Салбарын нийт зээлийн 77% буюу 10,590 сая ам.долларын эх үүсвэр нь ААН-үүдийн гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Энэхүү зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


ААН-үүдийн экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 2,200 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	17,211	19,830	2,619	15%	100%
I. Засгийн газар	3,599	3,535	-65	-2%	18%
II. Төв банк	571	1,130	559	98%	6%
III. Банк	1,176	1,376	200	17%	7%
Богино хугацаат	106	260	154	145%	1%
Урт хугацаат	1,070	1,116	46	4%	6%
IV. Бусад сектор	2,836	3,199	363	13%	16%
Богино хугацаат	790	545	-246	-31%	3%
Урт хугацаат	2,046	7,727	5,681	278%	39%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	9,028	10,590	1,563	17%	53%

*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 12. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 13. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	Он			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2011	2012	2013	Дүн	2015/14	Дүн	2016/15
I. УРСГАЛ ДАНС	-1,375	-1,083	-1,050	292	21%	33	3%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-871	-724	-768	147	17%	-44	-6%
Кредит	1,337	1,227	1,247	-110	-8%	20	2%
Дебет	2,207	1,950	2,014	-257	-12%	64	3%
1. Бараа	-573	-459	-446	114	20%	13	3%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,203	1,057	1,088	-146	-12%	31	3%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	1,776	1,516	1,534	-260	-15%	18	1%
2. Үйлчилгээ	-298	-265	-321	33	11%	-56	-21%
Кредит	134	170	159	36	27%	-11	-6%
Дебет	432	435	480	3	1%	45	10%
2.1 Тээвэр	-80	-79	-61	1	1%	18	22%
Кредит	66	50	57	-16	-25%	8	15%
Дебит	146	129	119	-17	-12%	-10	-8%
2.2 Аялал	-94	-91	-114	3	3%	-24	-26%
Кредит	18	25	35	7	37%	10	42%
Дебит	112	116	150	4	4%	34	29%
2.3 Бусад үйлчилгээ	-124	-95	-146	29	24%	-51	-53%
Кредит	50	95	66	46	92%	-29	-31%
Дебит	174	190	212	16	9%	21	11%
3 Анхдагч орлого	-538	-389	-320	149	28%	69	18%
Кредит	12	15	14	3	28%	-1	-6%
Дебет	550	405	334	-146	-26%	-70	-17%
3.1 Ажилчдын цалин	-38	-80	-43	-42	-110%	37	47%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-500	-309	-277	191	38%	32	10%
3.3 Бусад	0	0	0	0	0%	0	0%
4 Хоёрдогч орлого	33	29	37	-4	-12%	7	25%
Кредит	88	95	83	8	9%	-12	-12%
Дебит	54	66	47	12	21%	-19	-29%
Үүнээс: Хувийн гуйвуулга	7	8	11	1	12%	3	42%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	26	22	26	-5	-18%	4	20%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт	29	28	43	-1	0%	14	0%
Кредит	0	0	0	0	0%	0	0%
Дебет	0	0	0	0	0%	0	0%
2. Хөрөнгийн шилжүүлэг	0	0	0	0	0%	0	0%
Кредит	29	28	43	-1	-3%	14	51%
Дебет	30	29	43	-2	-6%	15	51%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-1,346	-1,055	-1,008	291	22%	47	4%
III. САНХҮҮГИЙН ДАНС							
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-1,460	-2,272	-758	-813	-56%	1,514	67%
1. Шууд хөрөнгө оруулалт	-1,460	-2,272	-758	-813	-56%	1,514	67%
1.1 Актив	-1,300	-335	-420	965	74%	-85	-25%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	48	15	19	-33	-68%	3	23%
1.1.2 Өрийн хэрэгсэл	25	10	19	-14	-58%	9	87%
1.2 Пассив	23	5	-1	-18	-79%	-5	-110%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1,348	350	439	-998	-74%	89	25%
1.2.2 Өрийн хэрэгсэл	618	-82	78	-700	-113%	160	195%
2. Багийн хөрөнгө оруулалт	730	432	361	-298	-41%	-71	-16%
2.1 Актив	-86	-1,469	134	-1,383	17x	1,603	109%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-66	5	7	71	108%	2	36%
2.1.2 Өрийн бичиг	9	5	11	-4	0%	6	129%
2.2 Пассив	-75	0	-4	76	100%	-4	21x
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	20	1,474	-127	1,454	7233%	-1,601	-109%
2.2.2 Өрийн бичиг	-1	-15	-2	-14	-1306%	13	88%
2.2.2.1 Богино хугацаат	21	1,489	-125	1,468	0%	-1,614	0%
2.2.2.2 Урт хугацаат	0	0	0	0	0%	0	0%
3. Санхүүгийн үсмэл хэрэгслэлд	21	1,489	-125	1,468	70x	-1,614	-108%
3.1 Актив	0	0	0	0	0%	0	0%
3.2 Пассив	0	0	0	0	0%	0	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	0	0	0	0	0%	0	0%
4.1 Актив	-73	-468	-472	-395	-541%	-3	-1%
4.1.1 Бусад хөрөнгө	398	39	140	-358	0%	100	0%
4.1.2 Бэлэн мөнгө ба харишцах	0	0	0	0	0%	0	0%
4.1.3 Зээл	310	8	181	-303	-98%	174	24x
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	-1	-1	-1	0%	0	0%
4.1.5 Худалдааны зээл ба үрждчилгаа	0	0	0	0	0%	0	0%
4.1.5.1 Богино хугацаат	87	33	-41	-54	-62%	-73	-225%
4.1.5.2 Урт хугацаат	87	33	-41	-54	0%	-73	0%
4.1.5 Бусад авлага	0	0	0	0	0%	0	0%
4.2 Пассив	0	0	0	0	0%	0	0%
4.2.1 Бусад хөрөнгө	471	508	611	37	0%	104	0%
4.2.2 Бэлэн мөнгө ба харишцах	0	0	0	0	0%	0	0%
4.2.3 Зээл	75	158	194	83	111%	36	23%
4.2.3.1 Төв банк	222	372	381	150	0%	9	0%
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	0	0	0	0	0%	0	0%
4.2.3.3.1 Богино хугацаат	25	89	204	64	261%	116	131%
4.2.3.3.2 Урт хугацаат	13	-20	120	-33	-260%	141	696%
4.2.3.2 Засгийн газар	12	109	84	97	814%	-25	-23%
4.2.3.4 Бусад салбар	129	80	48	-49	-38%	-32	-40%
4.2.3.4.1 Богино хугацаат	68	203	129	135	197%	-74	-36%
4.2.3.4.2 Урт хугацаат	39	34	-32	-6	-15%	-66	-196%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	29	170	161	141	0%	-8	0%
4.2.5 Худалдааны зээл ба үрждчилгаа	0	0	0	0	0%	0	0%
4.2.5.1 Богино хугацаат	173	-23	36	-196	-113%	59	259%
4.2.5.2 Урт хугацаат	173	-23	36	-196	0%	59	0%
4.2.6 Бусад авлага	0	0	0	0	0%	0	0%
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0	0%	0	0%
IV. Алдаа болон орхигдуулга	0	0	0	0	0%	0	0%
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	-301	31	-199	332	110%	-229	-747%
1. ГВУН	-188	1,248	-448	1,436	764%	-1,696	-136%
2. ОУВС-гийн зээл	0	0	0	0	0%	0	0%
3. Тусгай санхүүжилт	-187.85	1248.07	-448.29	1,436	0%	-1,696	-136%

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	3/31/2013	6/30/2013	9/30/2013	12/31/2013
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(6,489)	(12,314)	(19,238)	(20,930)	(22,473)	(23,563)	(24,642)
Актив	6,221	6,127	6,753	5,951	4,906	4,552	4,340
Шууд хөрөнгө оруулалт	2,616	1,757	883	290	305	330	351
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	2,595	1,704	817	223	234	260	282
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	2,595	1,704	817	223	234	260	282
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	20	54	66	66	71	70	69
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	20	54	66	66	71	70	69
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	359	202	485	447	362	200	370
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	308	196	479	437	352	190	365
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	(0)	2	3
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	308	196	479	437	352	188	362
Бусад санхүүгийн байгууллага	4	32	77	77	81	80	92
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	304	165	402	359	271	108	270
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	51	6	6	10	10	10	6
Төв банк	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	4	4	4	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	4	4	4	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	51	6	6	6	6	6	6
Богино хугацаат	6	6	6	6	6	6	6
Урт хугацаат	45	0	0	0	(0)	(0)	(0)
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	6	6	6	6	6	6	6
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	45	(0)	(0)	(0)	(0)	(0)	(0)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	1	0	1	11	13	49
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	1	0	1	11	13	49
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлшлүүд	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	959	1,318	1,259	1,417	1,272	1,481	1,404
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	839	1,033	896	993	907	1,102	1,100
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	503	500	530	475	459	525	489
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	335	533	366	518	447	577	611
Зээл	18	14	15	16	18	18	6
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	18	9	15	15	15	13	2
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	5	0	1	4	4	3
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	101	271	348	409	347	362	298
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	2,288	2,847	4,126	3,797	2,956	2,528	2,166

Эх сурвалж: Монголбанк

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	3/31/2013	6/30/2013	9/30/2013	12/31/2013
Өр төлбөр	12,711	18,440	25,991	26,881	27,378	28,115	28,981
Шууд хөрөнгө оруулалт	8,445	13,333	17,668	18,559	18,949	19,145	19,579
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	5,459	7,380	8,641	8,829	8,801	8,884	8,989
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	5,459	7,380	8,641	8,829	8,801	8,884	8,989
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	2,986	5,953	9,028	9,730	10,147	10,260	10,590
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	2,986	5,953	9,028	9,730	10,147	10,260	10,590
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	487	564	2,895	2,843	2,714	2,631	2,494
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	124	151	140	129	123	110	114
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	11	11	11	11
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	113	140	129	118	112	99	103
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	364	413	2,755	2,714	2,592	2,521	2,380
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	242	258	547	553	526	511	400
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	114	127	1,587	1,557	1,484	1,452	1,415
Бусад салбарууд	8	28	621	603	582	558	565
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	1	0	1	11	14	49
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	1	0	1	11	14	49
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	3,779	4,542	5,427	5,478	5,704	6,326	6,859
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	35	130	480	496	611	988	1,151
Төв банк	0	0	337	322	407	817	990
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	35	130	143	174	204	171	161
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Зээл	3,564	4,063	4,559	4,528	4,726	4,924	5,275
Төв банк	274	268	235	206	184	163	141
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	235	352	486	486	566	602	815
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	1,769	1,917	2,012	1,967	2,059	2,089	2,119
Бусад салбарууд	1,287	1,526	1,826	1,868	1,916	2,070	2,200
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	180	350	389	455	368	413	433
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	3/31/2013	6/30/2013	9/30/2013	12/31/2013
Засгийн газар	1,882	2,043	3,599	3,524	3,543	3,541	3,535
Төвбанк	274	268	571	528	591	980	1,130
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас	512	740	1,176	1,214	1,296	1,283	1,376
Бусад салбарууд	1,474	1,905	2,836	2,926	2,867	3,042	3,199
Шууд хөрөнгө оруулалт: Компани	2,986	5,953	9,028	9,730	10,147	10,260	10,590
хоорондын зээллэг							
Нийт гадаад өр	7,128	10,908	17,211	17,922	18,444	19,107	19,830

Эх сурвалж: Монголбанк